



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16.
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2018.02.05 № 3/257
таяй -ны № -т

**Шинэчилсэн заавар хүргүүлэх
тухай**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу малчны тэтгэвэр тогтоолгох насыг 5 жилээр наашлуулсан зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн A/02 дугаар тушаалаар баталсан "Малчин-даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах заавар"-ыг хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга болон холбогдох бусад удирдлагууд аймаг, дуургийн нийгмийн даатгалын хэлтсийн байцаач нарьг мэргэжил, арга зүйгээр хангах, зааврыг нэгдсэн ойлголтоор хэрэгжүүлэх, малчин-даатгуулагчид тэтгэвэр тогтоох явцад орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох, санал солилцох зорилгоор 21 аймаг, Багануур, Налайх дүүргийг хамруулан зохион байгуулсан телефон хурлаас гарсан саналыг тусган "Малчин-даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах заавар"-т нэмэлт, өөрчлөлт оруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн A/09 дүгээр тушаалаар баталсныг хүргүүлж байна.

Иймд малчин-даатгуулагчид тэтгэвэр тогтооход шинээр баталсан зааврыг баримталж ажиллахыг мэдэгдье.

Мөн аймаг, сумын архивын хэлтэс, тасагт хадгалагдаж байгаа малчин-даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг нотлох үндсэн баримт бичиг болох "Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ... оны тооллого"-ын жил бүрийн бүртгэл буюу "А" дансны лавлагаа гарах боломжтой болон боломжгүй аймаг, сумдын дэлгэрэнгүй судалгааг 2018 онд тэтгэвэр тогтоолгох болзол хангасан малчин-даатгуулагчдын судалгааны хамт хүргүүлсэн хүснэгтээр гарган 2018 оны 02 дугаар сарын 09-ний дотор ирүүлнэ үү.

Хавсралт 3 хуудастай.

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГААНЫ
ГАЗРЫН ДАРГА**

Ц.ГАНЦЭЦЭГ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 02 өдөр

Дугаар A/09.

Улаанбаатар хот

Зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах, лавлагаа түүхийн
болов тодорхойлолтын загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 1/73 тоот “Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Малчин-даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах заавар”-ыг нэгдүгээр, “Аймаг, сумын архивын хэлтэс, тасгаас малчин-даатгуулагчид олгох архивын лавлагааны загвар”-ыг хоёрдугаар, “Сум, баг, хорооны Засаг даргын тодорхойлолтын маягтын загвар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Зааврыг үйл ажиллагаандaa хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ийн дарга нарт, зааврыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т, зааварт нийцүүлэн холбогдох програм хангамжид өөрчлөлт оруулж, 2018 оны 02 дугаар сарын 05-ны дотор аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэх арга хэмжээ авахыг Мэдээллийн технологийн төв /Г.Хүрэлбаатар/-д тус тус даалгасугай.

Гурав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга /Г.Саран/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн A/02 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЗОРИГТ

1000037




НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

МАЛЧИН-ДААТГУУЛАГЧИД ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР
ТОГТООХОД БАРИМТЛАХ ЗААВАР

Баримт бичгийн дугаар: ЗВР-НДБХСГ- 01-2018

Баталсан:	Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга		Д.ЗОРИГТ
Хянасан:	Дэд дарга		Г.САРАН
	Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга		Ц.ГАНЦЭЦЭГ
Боловсруулсан:	Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газрын мэргэжилтэн		М.БЯМБАДУЛАМ

Эх хувь	Дардас
Хяналттай хувь	
Хуулбар хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	



№ 9081739 111815



Баримт бичгийн үндсэн мэдээлэл

Баримт бичгийн хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
ЭМНДЕГ-ЫН НДБХСГ	A/02	2018.01.17	2018.01.01	11

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл

Нэмэлт өөрчлөлт	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1	2018.02.02	Нэмэлт, өөрчлөлт	М.Бямбадулам
Хувилбар 2			
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			
Хувилбар 6			

Хувилбар 2



АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Малчин-даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох
6. Малчин-даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тооцох
7. Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд хамаарахгүй хугацаа
8. Малчин-даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтооход бүрдүүлэх баримт бичиг
9. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн болон энэ зааврын хэрэгжилтэд хяналт тавих
10. Хариуцлага

Хувилбар 2



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2018 оны 21. дүгээр сарын 02.-ний өдрийн
10. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**МАЛЧИН-ДААТГУУЛАГЧИД ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР
ТОГТООХОД БАРИМТЛАХ ЗААВАР**

НЭГ. Зорилго

1.1. Энэхүү зааврын зорилго нь Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалд даатгуулж, шимтгэл төлсөн даатгуулагчийн малчнаар ажиллаж, шимтгэл төлсөн хугацааг тооцох, холбогдох баримт бичгийг хянаж баталгаажуулах, түүнд тэтгэвэр тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д зааснаар мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг малчин гэж ойлгоно.

1.3. Түүнчлэн "малчин"-д энэ зааврын 1.2-т зааснаас гадна аж ахуй нэгж, байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр мал маллаж байсан малчин, **саальчин, тугалчин, тууварчин /1990 оноос өмнөх тууварчинг хамааруулна/, цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан мөн сайн дурын даатгалд даатгуулж шимтгэл төлсөн малчин Монгол Улсын иргэн /цаашид "малчин-даатгуулагч" гэх-/ийг хамааруулна.**

ХОЁР. Хамрах хүрээ

2.1. Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тооцож өндөр насны тэтгэвэр тогтоох.

ГУРАВ. Хамаарах талууд

3.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (газар), тасаг, сумын байцаагч.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

4.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Хяналт, шалгалтын газар, Санхүү бүртгэлийн газар.

**ТАВ. Малчин-даатгуулагчид өндөр насны
тэтгэвэр тогтоох**

5.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7-д заасан доор дурдсан болзлыг хангасан малчин-даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтооно:

5.1.1. Нийгмийн даатгалын шимтгэлийг нийт 20-оос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй малчин-даатгуулагч 55 нас хүрсэн бол;

Хувилбар 2



5.1.2. Нийгмийн даатгалын шимтгэлийг нийт 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй малчин-даатгуулагч 50 нас хүрсэн бол.

5.2. Малчин-даатгуулагчийн өндөр насын тэтгэвэр тогтоолгох насыг жил бүр 6 сараар нэмэгдүүлэхгүйгээр энэ зааврын 5.1-д заасан нас (эрэгтэй-55, эмэгтэй-50 нас)-ыг баримтлан тэтгэвэр тогтооно.

5.3. Энэ зааврын 5.1-д заасан болзол, нөхцөлийг хангасан малчин-даатгуулагчид тогтоох өндөр насын тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлсон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан хувь хэмжээгээр, мөн хуулийн 24.1.1-д заасан хугацаанд тогтоож, олгоно.

ЗУРГАА. Малчин-даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тооцох

6.1. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) даатгуулагчийн 1995 оноос өмнө малчнаар ажилласан хугацааг доор дурдсан баримт бичгийг үндэслэн тодорхойлно. Үүнд:

6.1.1. Хөдөлмөрийн дэвтэр болон хөдөө аж, ахуйн нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтэр, байхгүй эсхүл бичилт нь шаардлага хангахгүй тохиолдолд архивын лавлагаа, шүүхийн шийдвэрийг үндэслэн дор дурдсан байдлаар жилийг тооцно;

- 1968 он хүртэл хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн эмэгтэй малчныг хуанлийн жилд 110, эрэгтэй малчныг 150 хоног ажилласан тохиолдолд нэг жил шимтгэл төлж ажилласнаар тооцох;

- 1968 оны 01 дүгээр сарын 01-нээс 1991 он хүртэл хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн малчин /эмэгтэй, эрэгтэй/-ыг хуанлийн жилд 250 ба түүнээс дээш хоногоор ажилласан тохиолдолд нэг жил шимтгэл төлж ажилласнаар тооцох;

- Харин нэгдлийн гишүүн малчин дээрх онуудад хуанлийн жилд бүрэн ажиллавал зохих 110, 150, 250-иас доош хоног ажилласан тохиолдолд тухайн малчны нийт ажилласан хоногийг 30 хоногт хувааж тухайн жилд ажилласан сарыг тооцно.

6.2. Даатгуулагчийн 1991-1995 он хүртэл малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг доор дурдсан баримт бичгийг үндэслэн тодорхойлно. Үүнд:

6.2.1. Даатгуулагч 1991-1995 оны хооронд хувиараа мал маллаж байх хугацаанд Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн сайдын 1991 оны 276 дугаар тушаалын дагуу сайн дурын үндсэн дээр нийгмийн даатгалд хамрагдаж, орлогоосоо 13.5 хувиар тооцон тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн нь хөдөлмөрийн дэвтэр болон “нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг бүртгэх тооцоны хуудас”, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримт болон Үндэсний статистикийн хорооноос баталсан “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ... оны тооллого”-ын жил бүрийн бүртгэл (цаашид “А” данс гэх);



6.2.2. Энэ зааврын 6.2.1-д заасан даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг улсын байгууллагад ажиллагчдын хугацаатай нэгэн адилаар тооцно.

6.2.3. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу 1991-1994 оны хооронд ажилласан жилээ нөхөн тооцуулсан малчин-даатгуулагчийн уг хугацаанд малчнаар ажилласан хугацааг энэ зааврын 6.1, 6.2-т заасан баримт бичгийг үндэслэн тооцно.

6.3. Даатгуулагчийн 1995 оноос хойш малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг доор дурдсан баримт бичгийг үндэслэн тооцно. Үүнд:

6.3.1. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан нөхцөл журмын дагуу 1995 оноос хойш албан журмын болон сайн дурын даатгалд даатгуулж шимтгэл төлсөн даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг түүний малчнаар ажилд авсан, чөлөөлсөн тухай тушаал, нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан сайн дурын даатгалын гэрээ, баталгаажсан нийгмийн даатгалын дэвтэр, “А” дансны лавлагаа;

6.3.2. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу 1995-2000 оны хооронд тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн төлсөн малчин-даатгуулагчийн уг хугацаанд малчнаар ажилласныг нотлох энэ зааврын 6.3.1-д заасан баримт бичиг зэрэг болно.

6.4. Малчин-даатгуулагчийн малчнаар ажилласан хугацаа нь энэ зааврын 6.1, 6.2, 6.3.1-т заасан баримт бичгээр нотлогдоогүй тохиолдолд уг хугацааг тухайн даатгуулагчийн шимтгэл төлсөн нийт хугацаанд оруулан тооцож, харин малчнаар ажилласан хугацаанд хамааруулахгүй.

6.5. Малчин-даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 4.1-д заасан 15 наснаас эхлэн тооцно.

6.6. Малчин-даатгуулагчийн малчнаар ажилласныг нотлох “А” дансны лавлагааг энэ тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу дараах байдлаар гаргуулна. Үүнд:


6.6.1. Архивын лавлагаа гаргах загварын ард “А” дансны жил бүрийн бүртгэлийн зөвхөн эхний нүүрний овог, нэр, ам бүлийн тоо, тухайн өрхийн 16-аас дээш насны нийт малчдын тоо зэрэг мэдээлэлтэй хэсгийг хуулбарлан лавлагааны хамт хавсаргана.

6.6.2. Аймаг, сумын архивын хэлтэс, тасгаас гаргасан “А” дансны лавлагааны үндэслэлийг аймаг, сумын нийгмийн даатгалын байцаагч архивын эх баримттай тулган баталгаажуулна. Лавлагааны мэдээлэл зөрсөн тохиолдолд архивын лавлагааг дахин гаргуулна.

6.7. Сум, баг, хорооны Засаг дарга малчин-даатгуулагчид ам бүлийн тодорхойлолтыг энэ тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу дараах байдлаар гаргана. Үүнд:

6.7.1. Малчин-даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох үед хүсэлт гаргасан оршин суугаа сум, баг, хорооны Засаг дарга тодорхойлно;

Хувилбар 2





6.7.2. Малчин-даатгуулагчийн өөр аймаг, дүүрэг, суманд малчнаар ажиллаж байсан хугацаа нь “А” дансаар тодорхойлогдож байвал уг хугацааны ам бүлийн тодорхойлолтыг авахгүй.

6.8. Малчин-даатгуулагчтай хамтын амьдралтай байсан иргэний шүүхээр тогтоосон хугацаанд тухайн иргэнийг өрхийн гэр бүлийн гишүүн-малчнаар ажилласанд тооцно.

ДОЛОО. Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд хамаарахгүй хугацаа

7.1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3-т зааснаас гадна малчин-даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд дараах хугацааг хамаарулахгүй. Үүнд:

7.1.1. Цэргийн алба хаасан хугацаа;

7.1.2. Хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас алдсаны улмаас нийгмийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авсан болон халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авч байсан хугацаа зэрэг болно.

7.2. Малчин-даатгуулагч тахир дутуугийн тэтгэвэр болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авч байсан хугацаандаа нийгмийн даатгалд сайн дурын үндсэн дээр хамрагдаж шимтгэл төлсөн тохиолдолд уг хугацааг малчнаар ажилласан хугацаанд тооцохгүй, харин нийт шимтгэл төлж ажилласан хугацаанд оруулан тооцно.

7.3. Малчин-даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааны “А” дансны бүртгэл устсан, үрэгдсэн тохиолдолд малчнаар ажилласан хугацааг шүүхээр сэргээн тогтоолгож болно.

7.4. 1995 оноос хойш нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй малчны шүүхээр сэргээн тогтоолгосон хугацааг малчнаар ажиллаж, шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцохгүй.

7.5. Малчин-даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан ажил, мэргэжилтэй нэгтгэн тооцохгүй бөгөөд уг хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр тэтгэвэр тогтоохгүй.


НАЙМ. Малчин-даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтооход бүрдүүлэх баримт бичиг

8.1. Малчин-даатгуулагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичгээс гадна дараах баримт бичгийг үндэслэн өндөр насны тэтгэвэр тогтооно. Үүнд:

8.1.1. Аймаг, сумын архивын хэлтэс, тасгаас малчин-даатгуулагчид гаргасан “А” дансны лавлагaa;

8.1.2. Сум, баг, хорооны Засаг даргын тухайн малчин-даатгуулагчийн ам бүлийн талаарх энэ тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан тодорхойлолт.

Хувилбар 2





8.1.3. Эмэгтэй малчин-даатгуулагч өндөр насын тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан тохиолдолд гэр бүлийн баталгаа, эсхүл лавлагаа, **байхгүй тохиолдолд шүүхийн шийдвэр;**

8.1.4. 1995 оноос хойш Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу албан журмын даатгалд даатгуулсан малчин-даатгуулагчийн нийгмийн даатгалын дэвтрийн бичилт, баталгаажилт нь зохих журамд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд түүний малчнаар ажилд авсан, чөлөөлсөн тухай тушаал, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн архивын лавлагаа зэрэг болно.

**ЁС. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн болон
энэ зааврын хэрэгжилтэд хяналт тавих**

9.1. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь сумын болон хэлтсийн тэтгэврийн байцаагчийн малчин-даатгуулагчийн малчнаар ажилласныг нотолсон болон өндөр насын тэтгэвэр тогтоохоор бүрдүүлсэн баримт бичгийн үндэслэл, түүний тэтгэвэр тогтоолтыг хянан баталгаажуулна.

9.2. Нийгмийн даатгалын байгууллага нь орон нутгийн засаг захиргааны нэгжтэй хамтран ажиллаж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.

9.3. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь орон нутгийн засаг захиргааны нэгжтэй хамтран ажиллах бөгөөд засаг захиргааны нэгж нь малчин-даатгуулагчид өндөр насын тэтгэвэр тогтооход шаардлагатай холбогдох баримт бичгийг гаргаж өгөх нөхцөл, боломжоор хангах, холбогдох ажилтан (сум, баг, хорооны Засаг дарга, статистикийн мэргэжилтэн, архивын ажилтан зэрэг)-ы үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

АРАВ. Хариуцлага

10.1. Малчин-даатгуулагч өндөр насын тэтгэвэр тогтоолгох баримт бичгийг хуурамчаар үйлдэхийг хориглоно.

10.2. Нийгмийн даатгалын байгууллага нь хууль тогтоомжийн хүрээнд иргэд, малчин-даатгуулагчдад түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж, тэдгээрийг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллана.

10.3. Аймаг, дүүрэг, сумын архивын ажилтан “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ... оны тооллого”-ын жил бүрийн бүртгэлийн хуулбар болон малчнаар ажилласан жил, цалин хөлстэй холбоотой баримт бичгийн лавлагааг үндсэн баримттай нь тулган үнэн зөв гаргаж өгнө.

10.4. Энэ зааврын 10.1-10.3-т заасан үүргийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Статистикийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

- - - o O o - - -

Хувилбар 2



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2018 оны 02 дүгээр сарын 02-ний өдрийн
8/09 дугаар тушаалын хавсралт

**АЙМАГ, СУМ, ДҮҮРГИЙН АРХИВЫН ТАСАГ, ХЭЛТСЭЭС
МАЛЧИН-ДААТГУУЛАГЧИД ОЛГОХ АРХИВЫН
ЛАВЛАГААНЫ ЗАГВАР**

20.....оныдугаар
сарын-ний өдөр

Дугаар

9081739 1118156663 AMT01127

/аймаг, хот/

.....аимаг.....сум /дүүрэг/-ын.....баг /хороо/-ийн малчин, өрхийн тэргүүлэгч
/РД №...../.....овогтой-ний мал маллаж байсан хугацаа
/.....оноос.....он хүртэлх/

Малын төрөл	Тухайн онуудын жилийн эцсийн мал тооллогын "А" дансанд бүртгэгдсэн малын тоо									
	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000
Адуу										
Тэмээ										
Үхэр										
Хонь										
Ямаа										
Бүгд дүн										
Хн-№										

Малын төрөл	Тухайн онуудын жилийн эцсийн мал тооллогын "А" дансанд бүртгэгдсэн малын тоо									
	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010
Адуу										
Тэмээ										
Үхэр										
Хонь										
Ямаа										
Бүгд дүн										
Хн-№										

Малын төрөл	Тухайн онуудын жилийн эцсийн мал тооллогын "А" дансанд бүртгэгдсэн малын тоо									
	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Адуу										
Тэмээ										
Үхэр										
Хонь										
Ямаа										
Бүгд дүн										
Хн-№										

(Тайлбар: нөхөр, эхнэр нас барсан бол овог, нэр, нас барсан оныг бичнэ)

Архивч/...../

Лавлагааг хянасан:

Лавлагааны үндэслэлийг шалгаж баталгаажуулсан:

Архивын эрхлэгч /сумын ЗДТГ-ын дарга/:

Нийгмийн даатгалын байцаагч:

...../...../

...../...../

.....он.....кар.....өдөр

.....он.....кар.....өдөр

Хувилбар 2



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2018 оны 02 дүгээр сарын 02-ний өдрийн
1/09 дугаар тушаалын хавсралт

СҮМ, БАГ, ХОРООНЫ ЗАСАГ ДАРГЫН
ТОДОРХОЙЛОЛТЫН ЗАГВАР

9081739 1118156653 AMT01127

20.....оныдугаар
сарын-ний өдөр

Дугаар

.....баг, хороо

Малчин.....регистрийн дугаартай.....овогтой.....
ам бүл.....эхнэр, нөхөр (хамтын амьдралтай).....регистрийн
дугаартай,.....овогтой....., 16-аас дээш насны хүү,
охин.....тэй.....
.....
.....

хамт амьдардаг болохыг тодорхойлов.

ГАРЫН ҮСЭГ

Хувилбар 2

13	Сүхбаатар аймаг	1	
		2	
14	Сэлэнгэ аймаг	1	
		2	
15	Төв аймаг	1	
		2	
16	Усас аймаг	1	
		2	
17	Ховд аймаг	1	
		2	
18	Хөвсгөл аймаг	1	
		2	
19	Хэнтий аймаг	1	
		2	
20	Орхон аймаг	1	
		2	
21	Говьсүмбэр аймаг	1	
		2	

Тайлбар:

- * Баганы дугаар 7 буюу Тайлбар хэсэгт А дэсныг хавна, хэдэн онд урзгүүлсэн шалтгааныг дэлгэрэнгүй бичих;
- * Баганы дугаар 5, 6 хэсэгт А дэсний сүүлийн байдлаар хадгалагдаж байгааг он тус бүрээр бичих;
- * Баганы дугаар 3 хэсэгт бүх сумийн судалгааг гарах;
- * Баганы дугаар 2 хэсэгт тимм/үгий гэж бичих.

2018 онд тэтгэвэр тогтоолгох малчин-даатгуулагчийн болон "Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын баримт" /А данс/ -ны дэлгэрэнгүй судалгаа

№	Дүүргийн нэр	"А" дансны баримт байгаа эсэх	Үнээс: Хэдээс хадэн оны "А" дансны баримт байхгүй бол шалтгааны дэлгэрэнгүй бичих	Дүүргийн архивт байгаа	"А" дансны баримт байхгүй бол шалтгааны дэлгэрэнгүй бичих	Нийт малчны тоо	2018 онд тэтгэвэр тогтоолгох малчны тоо	Тэтгэвэр тогтоолгох баримт үүчиг нь бүрэн малчны тоо	Тэтгэвэр тогтоолгох баримт үүчиг нь бүрэн малчны тоо	Тэтгэвэр тогтоолгох баримт үүчиг нь бүрэн малчны тоо	Үнээс:	Хэрэв тэтгэвэр тогтоолгох баримт үүчиг нь бүрэн малчны тоо
1	Налайх дүүрэг	2	3	4	5	6	7	8	9	10		
2	Батанур дүүрэг											
3	Багахангай дүүрэг											
4	Баянзүрх дүүрэг											
5	Баянгол дүүрэг											
6	Чингэлтэй дүүрэг											
7	Сонинжохижан дүүрэг											
8	Сүхбаатар дүүрэг											
9	Хан-Уул дүүрэг											

Тайлбар:

Баганы дугаар 5 буюу тайлбар хэсэгт А дансны баримт хаана, хэдэн онд үргэлжлэн шалтгааны дэлгэрэнгүй бичих.

Баганы дугаар 3, 4 хэсэгт А дансны баримт хамгийн сүүлийн байдлаар хадна хадгалац даж байгааг он тус бүрээр бичих.

Баганы дугаар 2 хэсэгт Тимм/Гүй гэж бичих.